

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ
АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО,
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Л.Энх-Амгалан**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2015 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл, Д.Хаянхярваа, Л.Энх-Амгалан, Л.Эрдэнэчимэг нар үндсэн чиглэлд ажилгүйдлийн түвшинг бууруулах, олон хүүхэд төрүүлсэн эх, гэр бүлийг дэмжсэн хөтөлбөр болон хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцох аргачлалыг тусгасан эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт, Г.Баярсайхан, Д.Хаянхярваа нар цаашид үндсэн чиглэлд тунхагийн зүйл бус гол асуудлаа тусгаж байх, хөгжлийн бодлогоо зөв, оновчтой тодорхойлж, хүрэх түвшин, үнэлэх аргачлалаа тодорхой болгох нь зүйтэй гэсэн санал гаргасан болно.


Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийн хамт Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

“Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын
хорооны дэмжсэн санал:**

1.Төслийн 19 дүгээр зорилтод “Олон хүүхэд төрүүлсэн эх, олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл,
Д.Сумъяабазар, Д.Хаянхярваа, Л.Энх-Амгалан**

2.Төслийн 19 дүгээр зорилтод “Малчдын хөдөлмөрийн онцлогийг харгалзан тэтгэврийн насыг өөрчлөх асуудлыг судалж шийдвэрлэнэ” гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл,
Д.Сумъяабазар, Д.Хаянхярваа, Л.Энх-Амгалан**

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын
хорооны дэмжээгүй санал:**

3.Төслийн 19 дүгээр зорилтод “Ахмадуудаа халамжлах, ач санах хуультай болно” гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл,
Д.Сумъяабазар, Д.Хаянхярваа, Л.Энх-Амгалан**